ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

“ЭСТАКАДАН ГҮҮРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ” АЖЛЫН ДААЛГАВАР

ТӨСӨВ: 717’444’000.00 төгрөг

Улаанбаатар хот

БАТЛАВ.
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХҮРЭВЖАРГАЛ

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

“ЭСТАКАДАН ГҮҮРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ” АЖЛЫН ДААЛГАВАР

1.	Байршил	Монгол улс, Өмнөговь аймаг, Ханбогд, Хайрхан баг
2.	Захиалагч	“Тавантолгой төмөр зам” ХХК
3.	Гүүрийн овор хэмжээ, замын техникийн ангилал	Нийт урт 9,413.46м гүүр; - Гүүр-1. Нарийн цариг дан зам-2,723.9м, Өргөн цариг дан зам-4,256.61м, Хос царигтай-1,496.2м; - Гүүр-2 Нарийн цариг 936.75м;
4.	Ажлын зорилго	- Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам төслийн хүрээнд баригдах урт гүүрийн үе шатны ажлын чанар, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн барилга байгууламж батлагдсан зураг, төсөл, техникийн шаардлагын дагуу баригдаж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгч зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах; - “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн инженер, техникийн ажилтнуудад гүүрийн барилга угсралтын чиглэлээр сургалт зохион байгуулж мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд хамтарч ажиллах; - Сүүлийн үеийн дэвшилтэд технологи, багаж хэрэгслийн хэрэглээ, тэдгээрийн онцлог давуу талыг танилцуулж практикт нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахад оршино.
5.	Баримтлах норм ба дүрэм, стандарт	- Төмөрбетон бүтээц, хийцийн үйлдвэрлэл, угсралтын талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, норм, дүрэм дагаж мөрдөх;
6.	Гүйцэтгэх үндсэн үүрэг	**Эстакадан гүүрийн ажлын үе шатанд хяналт тавих, ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах чиглэлд хамаарах ажлын хүрээнд:**

		- Барилгын үе шатны ажлын чанар, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн барилга байгууламж батлагдсан зураг төсөл, техникийн шаардлага, технологийн дагуу баригдаж байгаа эсэхэд хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгөх; - Технологийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, тохиргоо зүгшрүүлэлтийн ажиллагаа үйлдвэрлэгчийн заавар, зураг төслийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих; - Төслийн ажил, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн процессын үйл ажиллагааны биелэлтийг хянах; - Барилгын ажлын гүйцэтгэгчийн боловсруулсан аргачлал, технологийн горимын схемийг хянах, техник технологийн сонголт, шийдлийн талаар санал боловсруулах; - Техникийн комисс болон улсын комисс ажиллах үед ажлын хэсэгт орж үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах; - Олон улсын туршлага дээр үндэслэн урт гүүр барих арга технологийг барилга угсралтын ажилд дээр нэвтрүүлэх; - Зөвлөхийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргах.
7.	Гүйцэтгэх хугацаа	- Гэрээнд заагдсаны дагуу;
8.	Онцгой нөхцөл	- Гүйцэтгэгч байгууллагын гэрээ дүгнэх хуралд суух; - Гүйцэтгэх үндсэн үүрэгтэй холбоотой төрийн болон Гүйцэтгэгч байгууллагуудын уулзалт, хурал, хэлэлцүүлэгт хамтран ажиллах; - Ажлын чиг үүрэгтэй холбоотой бусад үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэнэ;

ТАНИЛЦСАН:
ТУ ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХБАТ

ХЯНАСАН:
ТХ ХЭЛТСИЙН ДАРГА: Р.ОТГОНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
ТХ ХЭЛТСИЙН ГҮҮР ХООЛОЙН
ИНЖЕНЕР: М.ЭРДЭНЭДАЛАЙ